

# **XABCPAJT**

## **БУРХАНЫ ШАШНЫ ТОВЧ ТҮҮХ**

- Энэтхэгээс Япондуламжласан нь -

### **1. ЭНЭТХЭГ**

Төв Энэтхэгт "Азийн гэрэл гэгээ" гийж бадарсан нь хүн төрөлхтний оюуны амьдралд тохиолдсон нэгэн агуу бөгөөд эрин үеийн ач холбогдол бүхий үйл явдал болсон юм. Өөрөөр хэлбэл, олон зууны турш эдүгээ хүртэл азийнхны сэтгэлийг тэтгэсээр буй Агуу их оюун ухаан, Энэрэнгүй, Нигүүлсэнгүй сэтгэлийн булаг ундарсан нь тэр бүлгээ.

Хожим нь Бурхан багшийн сургаалыг дагагчдын Шагжамуни буюу "Шагжа омгийн Чадагчийн эрхт" хэмээн өргөмжилсөн Бурхан Гаутама, гэр орноо орхин явж, бадар барьж, лам болж, өмнө зүгийн Магадха хэмээх газар бодь модны дор гэгээрсэн юм. Энэ их ёслол манай эриний өмнөх тавдугаар зууны дунд орчим болсон хэмээн үздэг билээ. Түүнээс янагш тэрбээр "Агуу их Үхэл" хүртлээ буюу Нирванд ортлоо 45 жилийн турш Оюун ухаан, Энэрэнгүй, Нигүүлсэнгүй сэтгэлийн тухай сургаалаа уйгагүй номлосон юм. Улмаар Төв Энэтхэгийн янз бүрийн улс гүрэн, овог аймагт энэхүү шашин шүтлэгийн их үндэс суурь тавигдсан бүлгээ.

Маурья удмын гуравдахь хаан Ашока буюу Гаслангүй хааны үед (МЭӨ 268-232 онуудад захирч байжээ) Бурхан Гаутамагийн сургаал зарлиг түгэн дэлгэрч, тэр ч байтугай хилийн чанадад тархаж эхэлсэн аж.

Маурьягийнхан нь Энэтхэг орныг нэгтгэсэн анхны удам бүлгээ. Энэ удмын анхны хаан Чандрагуптын үед (МЭӨ 317-293 онуудад захирч байсан аж) Маурья удмын эзэмшил нутаг хойгуураа Хималайн уулс, зүүн талдаа Бенгалийн булан,

баруугаараа Гинду Кушийн улс, урдуураа Виндхьягийн улстай хил залгаж байлаа. Ашока хаан Калинга хэмээх өмнөд зүгийн орныг улс гүрэндээ нийлүүлж, улс нь Декканы улс хүртэл тэлсэн аж.

Энэ хаан харгис хатуугаараа алдаршиж хүмүүс түүнийг Чандашока буюу "Аймшигт Ашока" хэмээн нэрлэжээ. Гэвч Калинга улсыг байлдан дагуулж байхдаа цэргүүдийнхээ устгаж эвдсэн бүхнийг хараад зан ааш нь эрс өөрчлөгдөж, тэрбээр Оюун ухаан, Энэрэнгүй, Нигүүлсэнгүй сэтгэлийн сургаалыг үнэн сэтгэлээсээ шүтэн биширдэг болжээ. Түүнээс хойш Бурхан багшийн сургаалыг даган мөрддөг хүний хувьд олон сайн үйлийг бүтээснээс, хамгийн томоохон нь дараах хоёр үйл байлаа.

Эхнийх нь, "Ашокийн бичээс" юм. Тэрбээр эзэмшил нутагтаа газар сайгүй чулуун хөшөө босгож, түүн дээр энэхүү улс орны хаан Бурхан багшийн сургаалын дагуу улсаа захирч буйг сийлжээ. Ийм утгатай үгсийг өнгөлсөн хад асган дээр мөн адил сийлсэн байв. Хоёрдахь нь, тэрбээр Энэтхэг орон даяар Бурхан багшийн Оюун ухаан, Энэрэнгүй, Нигүүлсэнгүй сэтгэлийн сургаалыг түгээн дэлгэрүүлсэнд оршино. Түүнээс гадна тэрбээр энэхүү сургаалыг түгээн дэлгэрүүлэхээр элч нараа гадаадын олон оронд илгээжээ. Элч нараа Сири, Египет, Кирен, Македон, Эпир зэрэг алс холын орнуудад явуулсныг онцгой анхаарвал зохино. Тэд Бурхан багшийн сургаалыг алс холын баруун зүгт түгээн дэлгэрүүлжээ. Түүгээр ч зогсохгүй Тамрапарни буюу Шри-Ланкад очсон Махендра элч" үзэсгэлэнтэй сайхан сургаалыг үзэсгэлэнтэй сайхан Ланкадвипа арал дээр сайтар үндэслүүлсэн" байна. Ийнхүү урд зүгийн улс орнуудад ариун сургаалыг сурталчлах үндэс тавигджээ.

## **2. МАХАЯНА БУЮУ ИХ ХӨЛӨГНИЙ ШАШИН ҮҮССЭН НЬ**

Арай сүүлийн үеийн бурханы шашинтнууд "Бурханы сургаал дорнод зүг рүү түгсэн" гэж өгүүлэх нь олонтаа. Гэвч манай эриний өмнө бурханы сургаал өрнө зүг рүү хандаж байсан нь тодорхой. Энэхүү сургаал дорно зүг рүү манай эриний эхэнд хандаж эхэлсэн юм. Гэвч эхлээд бурханы шашинд гарсан нэгэн томоохон өөрчлөлтийн тухай хэлэх хэрэгтэй. Энэ нь "Махаяна" буюу "Их хөлөгний шашин" хэмээх "шинэ давалгаа" үүсэнд оршино. Улмаар "Махаяна" бурханы шашинд улам хүчтэй тодорч, улам хүчтэй байр суурьтай болсон юм.

Энэхүү "шинэ давалгаа" хэзээ буй болов? Хэрхэн бий болов? Хэн түүнийг үүсгэв? Энэ тухай хэн ч тодорхой хэлж чадахгүй билээ. Бидний баттай өгүүлж чадах нь: нэгдүгээрт, түүнийг тухайн үеийн тэргүүний лам хувраг нар бурханы сургаалын эхний үеийн Махасамгхикийн дэгийн үндсэн дээр бүтээсэн юм. Хоёрдугаарт, манай эриний өмнөх хоёр, нэгдүгээр зуун, мөн манай эриний нэгдүгээр зуун гэхэд Махаянагийн хамгийн чухал судар ном буй болсон байлаа. Нагаржуна эдгээр ном судрын үндсэн дээр гүн ухааны идэвхтэй үйл ажиллагаагаа явуулж эхлэхэд Махаяна нь бурханы шашны түүхийн тавцан дээр тодрон гарч ирсэн билээ.

Бурханы шашны түүхийн урт хугацаанд Махаяна ихээхэн чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Хятад, Японд бурханы шашин түүхийнхээ бүхий л хугацааны турш энэхүү чиглэлийн нөлөөн дор хөгжсөөр ирсэн билээ. Үүнд Ч гайхах юм үгүй. Учир нь Махаяна ард түмний хэрхэн аврагдахын шинэ зам

зорилтыг дэвшүүлсэн юм. Үүнийг хэрэгжүүлэхээр бодьсад нар хэмээх ариун явдалт шинэ хүмүүсийг дэвшүүлж гаргасан билээ. Түүгээр ч зогсохгүй тэднийг дэмжихийн тулд Махаянагийн сэтгэгчид метафизик, сэтгэл зүйн салбарт оюун ухааны томоохон ололт амжилт гаргасан юм. Үүний үр дүнд бурхан Гаутамагийн залгамж халааг үргэлжлүүлсэн Махаяна нь Оюун ухаан, Нигүүлсэнгүй сэтгэлийн сургаалд олон шинэ шинж чанарыг оруулжээ. Махаянагийн ачаар бурханы шашин илүү дайчин, илүү чин сэтгэлийн болжээ. Их устай мөрөн лүгээ адил энэхүү сургаал дорнын улс орныг тэтгэж эхлэв.

### **3. ТӨВ АЗИ**

Хятадууд анх Төв Азиар дамжин бурханы шашинтай танилцжээ. Тиймээс бурханы шашны Энэтхэгээс Хятадад ирсэн зам мөрийн тухай ярихдаа юуны өмнө торгон замыг дурьдах ёстой. Анх манай эриний өмнөх II зууны эцэст, Хятадын Хан улсын эзэн хаан У-дигийн хаанчлалын үед (МЭӨ 140-87 онуудад захирч байв) эл замыг Төв Азийн говь цөлийг дамжин Өрнө, Дорныг холбосон худалдааны зам гэж нээжээ. Тэр үед Хятадын нутаг дэвсгэр баруун зүгт нилээн сунасан байлаа. Хятадын хөрш зэргэлдээ оршиж байсан Фергана, Согд, Тохара, Парфи зэрэг оронд бүр Македоны Александрын үед үүсч тогтсон арилжаа наймааны уур амьсгал хэвээр байжээ. Эдгээр орны нутаг дэвсгэрийг дайрч өнгөрөх худалдааны замд хамгийн чухал бараа таваар бол хятадын торго хэмээн тооцдог байжээ. Тиймээс ч Торгон зам хэмээн нэрлэсэн аж. Энэтхэг, Хятадын хооронд голдуу бурханы шашны салбарт эхэлсэн соёлын харилцаа мөн адил энэхүү худалдааны замын ачаар тодорхой үйл хэрэг болж

байлаа. Тийм учраас бурханы шашны ирсэн зам нь Торгон зам юм.

#### 4. ХЯТАД

Хятадад бурханы шашны түүх, бурханы шашны ном судартай болж, тэдгээрийг орчуулснаар эхэлнэ. Эрт дээр үеэс эхлэн, анх сүүлийн Хан улсын эзэн хаан Мин-дигийн үед буюу Юнпины үед (МЭ 58-76 онууд) Касяпаматанга болон бусад лам хувраг "Ссу-ших-ер-чан-чин" (42 бөлөгтэй судар) судрыг авчран орчуулснаар эхэлсэн гэж үздэг билээ. Гэвч орчин үеийн эрдэмтдийн үзэж байгаагаар энэ нь эргэлзээтэй домог аж. Тэд анх Ань Ши-Гао, Лоянд байхдаа (МЭ 148-171 онуудад) энэ судрыг авчирч орчуулсан гэдгийг баталжээ. Түүнээс хойш Хойд Сүн улсын эзэн хаадын үе хүртэл <МЭ 960-1129 онууд) нэг мянган жилийн турш бурханы шашны ном судрыг орчуулах ажил үргэлжилжээ.

Эхний үед голдуу Төв Азийн лам хуврагууд Хятадад ном судар авчирч, тэдгээрийг хятад хэлээр орчуулахад голлох үүрэг гүйцэтгэж байв. Тухайлбал, Ань Ши-Гао Хятадад Парфи улсаас ирсэн байна. Ш зуунд Лоянд ирж, "Сукхавативьюха" нэрт судрыг орчуулсан Кан Сэн-Кай Самаркандаас ирсэн байв "Богдсын ном цагаан лянхуа" судрын орчуулагч хэмээн алдаршсан Чу Фа-Ху буюу Дармарагша нь Тохараас ирж, Лоян, Чанъаньд Ш зууны СҮҮЛ, Ү зууны эхэнд амьдарч байв. Ү зууны эхэнд Кумаражива Кучээс залран ирсний дараа бурханы шашны ном судрыг орчуулах ажил Хятадад оргилдоо хүрчээ.

Ойролцоогоор чухамхүү энэ үеэс эхлэн Хятадын лам хуврагууд самгарьд хэл сурахаар Энэтхэгт очих болов. Анх Энэтхэгт хүрсэн лам гэвэл Фа-сянь хуушаан (339-420?)

байлаа. Тэрбээр 399 онд Чанъаниас Энэтхэг рүү явж, 15 жилийн дараа буцаж иржээ. Тэдний дундаас хамгийн их алдаршсан нь Сюань-зуан (602-664) байсан юм. Тэрбээр 627 онд Энэтхэгт очиж, 645 онд буюу 19 жилийн дараа Хятадад буцаж ирсэн аж. И-уин (635-713) 671 онд Энэтхэг рүү далайгаар явж, 25 жилийн дараа Хятадад мөн адил далайгаар буцаж ирсэн аж.

Тэд, Энэтхэгт самгарьд хэл сурч, шилж сонгосон ном судраа аваад Хятадад буцаж ирдэг байсан бөгөөд тэдгээрийг хятад хэлээр орчуулахад өөрсдөө гол үүрэг гүйцэтгэдэг байв. Сюань-зуан хэлний онцгой авьяастайгаа харуулсан юм. Түүний уйгагүй үйл ажиллагааны ачаар бурханы шашны ном судрыг орчуулах ажил Хятадад бас нэг оргилдоо хүрчээ. Эрдэмтэд, Сюань-зуанаас өмнө Кумаражива болон бусад лам нарын хийсэн орчуулгыг "Хуучин орчуулга", харин Сюань-зуанаас хойш хийсэн орчуулгыг "Шинэ орчуулга" хэмээн тус тус ялгаж нэрлэдэг бүлгээ.

Энэхүү бурханы шашны баялаг орчуулгын ном судар дээр тулгуурласан хятадын лам хувраг нарын гүн ухаан, шашны үйл ажиллагаанд аажим аажмаар хятаджих чиг хандлага тодорч эхэлсэн юм. Энэ нь Хятадын үндэсний зан чанар, хятад үндэстний хэрэгцээ шаардлага болон түүний өөртөө итгэх итгэл бат бэх байсны тод илрэл юм. Үүнийг эхний үед хятадын лам хувраг нар Пражнягийн сударт өгүүлдэг "Хоосон чанар"-ын онолын метафизикийг ихэд анхааран сонирхож байсан тухай баримт гэрчилнэ. Удалгүй тэд, Хинаяна буюу Бага хөлөгний шашнаас татгалзаж гагцхүү Махаяна буюу Их хөлөгний шашныг сонирхож эхэлсэн баримт ч гэрчилнэ. Энэхүү чиг хандлага Тяньтай дэгт (Япон нэр нь Тэндай) тод томруун илэрч, Чань дэгт (Япон нэр нь Зэн) цэцэглэн хөгжсөн юм.

Хятадад Тяньтай дэг VI зууны хоёрдугаар хагаст, Агуу их Тяньтай багш (Япон нэр нь Тэндай Дайси) хэмээн алдаршсан III тэргүүн хамба Жи-и (538-597)-гийн үед бүрэлдэн тогтсон юм. Тэрбээр, Хятадын бурханы шашны гүн ухааны хамгийн гарамгай зүтгэлтний нэг байсан юм. Бурхан багшийн сургаалыг таван үе, найман номлолд хуваасан түүний ангилал урт удаан хугацааны турш Хятадаар зогсохгүй Японд ч гэсэн бурханы шашин хөгжихөд хүчтэй нөлөөлж байлаа.

Чухамхүү хэзээ үүссэнээс нь үл хамааран ном судрыг Хятадад авчирмагцаа шууд хятад хэлээр орчуулж байв. Бурханы шашны ном судрын баялаг нөөц хуримталсны дараа эдгээр судрын үүсэл, гарал, үнэ цэнийг шинээр ухааран тогтоох шаардлага урган гарсан юм. Бурханы шашныг бүхэлд нь ухаарсан өөрсдийн үзлийг тусгаж, тэдгээрийг боловсруулан гаргах, эдгээр үзлийн үндэслэл бүхий тайлбар сэлтийг тодорхойлох шаардлага гарч ирэв. Ийнхүү Жи-и болон бурханы шашны бусад сэтгэгчдийн ангилал буй болж, эдгээр нь юуны түрүүн хятадын гүн ухааны үзэл бодлын хөгжлийн үр дүн болсон юм. Тэдгээрээс Жи-и-гийн ангилал хамгийн эмх цэгцтэй, хамгийн итгэл үнэмшилтэй нь болсон аж. Гэвч бурханы шашны орчин үеийн судалгаа эхлэхэд энэхүү ангилал нь ноёлох нөлөөгөө алджээ.

Хятадын бурханы шашны түүхэнд Чань дэг нь (Япон нэр нь Зэн)"сүүлчийн ололт амжилт" болсон юм. Түүнийг хилийн чанадаас ирсэн номч мэргэн Бодидарма (-528) үүсгэсэн билээ. Бодидармагийн суулгасан үр гагцхүү зургадугаар тэргүүн хамба Хуэй-нэн (638-713) -ий дараа үзэсгэлэнт сайхан цэцэг лүгээ адил дэлгэрсэн юм. VIII зууны дараа энэхүү дэгээс дэлхийд гайхуулсан суут зүтгэлтнүүд тэд нарын үйл ажиллагааны ачаар эл дэг хэдэн зууны турш цэцэглэж байлаа.

Бурханы шашны үзэл бодол шинээр хөгжсөн нь хятадын



ард түмний үндэсний зан чанартай гүн гүнзгий холбоотой гэж болно. Энэ нь үнэн хэрэгтээ хятадын гүн ухааны санаа бодлоор тодотгосон бурханы шашин байлаа. Бурхан Гаутамагийн сургаалын гол мөрөнд шинэ урсгал цутгахад улам их устай болж, Хятадаас дорно зүгт байсан улс орныг шимт урсгалаараа тэтгэж эхэлсэн юм.

## 5. ЯПОН

Японы бурханы шашны түүх VI зуунаас эхэлдэг. 538 онд Пэкчэ улсын хаан, японы эзэн хаан Киммэйд элчээ Бурхан багшийн цутгамал баримал, бурханы шашны ном судар зэрэг бэлэгтэйгээр илгээжээ. Ингэж бурханы шашин Японд залран иржээ. Түүнээс хойш бурханы шашин Япон улсад даруй 1400 гаруй жил хөгжиж байна.

Бурханы шашны энэхүү урт удаан хугацааны түүхэнд хамгийн чухал гурван үеийг тэмдэглүүштэй.

Эхний үе нь VII, VIII зуун буюу Хоорю-жи сүм(607) барихаас эхлэн Тодай-жи сүм(752) барих хүртэл үеийг хамарна. Энэ үеийг тодорхойлохдоо Азийг тэр аяар нь хамарсан соёлын ер бусын хөгжил дэвшлийн давалгааг анзаарахгүй байж болохгүй. Тэр цагт өрнийн соёл иргэншил харанхуй бүдүүлэг, харин дорных нь идэвхтэй хөгжин өргөжиж байлаа. Хятад, Төв Ази, Энэтхэг болон бусад урд зүгийн орнуудад оюун ухаан, шашин шүтлэг, урлаг уран сайхны үйл ажиллагаа идэвхтэй өрнөж байсан юм. Бурханы шашин, хүний үйл ажиллагааны энэхүү олон төрлийг нэгтгэж, хүмүүнлэг үзлийн хүчит давалгаа болон Дорнын ертөнцийг ариун усаараа угааж эхэлсэн юм. Тэр үеийн Японы соёлын хөгжил нь үзэсгэлэн төгөлдөр Хоорю-жи сүм, сүрлэг агуу

Тодай-жи сүмийг барьж бүтээснээр болон энэ хоёр сүмийг тойрон өрнөсөн олон талт шашны болон урлаг, уран сайхны үйл ажиллагаагаар илэрсэн юм. Эл хөгжил дэвшил бүх Азийг хамарч эцэст нь түүний хамгийн зүүн хязгаарт хүрсэн соёлын агуу их давалгааны нөлөөн дор өрнөснийг хэлэх нь зүйтэй.

Эдүгээ хүртэл соёл иргэншлээс хол хөндий явсан Японд соёл нүд ирмэх зуур дэлгэрэн цэцэглэв. Чухамхүү бурханы шашин тэр үед олон улсын соёл түгээгч болж байлаа. Улмаар бурханы шашны сүм хийд олон улсын соёл иргэншлийн төв, лам хувраг нь шинэ, дэвшилт үзэл бодлыг дамжуулан түгээгч наран болж байлаа. Үзэл бодлыг хамгийн сайн агуулах зүйл нь ном судар байжээ. Тэд гагцхүү шашнаар зогсохгүй илүү өргөн цар хүрээтэй агуу чанартай соёлыг багтааж байв. Бурханы шашин Японд дэлгэрч эхэлмэгц гүйцэтгэсэн үүргийн үнэн зөв түүх ийм юм.

Удалгүй IX зуунд Сайчо (767-822), Кукай (774-835) хэмээх бурханы шашны хоёр томоохон зүтгэлтэн гарч иржээ. Тэд, Японы бурханы шашны анхны хоёр дэгийн суурийг тавьсан юм. Тэр үеийн бурханы шашныг Хэйаны дэгийн бурханы шашин хэмээнэ. Тэр үед бурханы шашныг юу ч хийдэггүй язгууртнууд сонирхдог зүйл хэмээн үзэх чиг хандлага байв. Гэвч энэ хоёр зүтгэлтэн, бурханы шашны мөн чанар, сэтгэлээ төгс төгөлдөр болгоход оршино хэмээн үзэж байсан учир үйл ажиллагаагаа хот суурин газраас уул хаданд шилжүүлж, тэнд сэтгэлээ төгс төгөлдөр болгох тусгай ариун шүтээн босгосон аж. Түүнээс хойш 300 гаруй жилийн турш тэд нарын Тэндай, Шингон дэгүүд голдуу эзэн хааны ордонд, язгууртнуудын дунд цэцэглэн дэлгэрч байлаа.

Хоёрдахь үе XII, XIII зууныг хамарна. Энэ үед Хоонэн (1133-1212), Шинран (1173-1262), Догэн (1200-1253),

Ничирэн (1222-1282) зэрэг японы бурханы шашны гарамгай зүтгэлтнүүд идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлсэн юм. Өнөөдөр Японд бурханы шашин дэлгэрсэн түүхийг өгүүлэхдээ бид эдгээр хүмүүсийн нэрийг дурьдахгүй өнгөрч хэрхэвч болохгүй. Гэвч ямар учраас чухамхүү энэ үе бурханы шашны олон гарамгай зүтгэлтнийг Япон улсад төрүүлсэн бэ? гэвэл энэ нь нэгдүгээрт, тэдний өмнө нэгдсэн зорилт байснаар тайлбарлагдана. Ямар зорилт вэ? гэвэл бурханы шашныг япон маягаар ухааран эзэмших явдал байлаа.

Бурханы шашин Японд бүр эрт нэвтэрсэн юм шүү ГЭЖ бидний хэлснийг эсэргүүцэж болох юм. Түүхэн баримтын хувьд энэ нь үнэн билээ. Гэвч аливаа улсын ард түмэн нэгэн соёлыг хүлээн авч, түүнийг боловсруулж, түүнд дасч, өөрийн болгоход хэд хэдэн зуун шаардагдана. Өөрөөр хэлбэл 7-8 дугаар зуунд Японы хүлээн авсан шашин 12, 13 дугаар зуунд сая цэцэглэсэн билээ. Энэ нь бурханы шашны зүтгэлтнүүдийн нөр их хөдөлмөрийн үр дүн юм.

Түүнээс хойш Японы бурханы шашин эдгээр гарамгай зүтгэлтний тавьсан суурин дээр хөгжсөн билээ. Улмаар тэр чигээрээ бидэнтэй учран золгож байгаа юм. Өөрөөр хэлбэл, түүнээс хойш Японы бурханы шашны түүхэнд үүнтэй адил дэвшил хөгжил өрнөөгүй билээ. Гэвч бидний бодож байгаагаар дараа нь японы бурханы шашны түүхэнд анхаарал татсан үйл явдал тохиолдсон юм. Энэ бол эртний бурханы шашны судлалд орчин үеийн эрдэмтдийн гаргасан ололтууд юм.

Японд бурханы шашин анх нэвтрэн орж ирснээсээ эхлэн хятадын бурханы шашны нөлөөн дор байсан юм. Энэ нь дан ганц Их хөлөгний сургаал байсан гэсэн үг. Ялангуяа 12, 13 дугаар зууны суут зүтгэлтнүүдийн дараа бүх дэг Махаяна буюу Их хөлөгний шашныг өвлөсөн юм. Ийм нөхцөлд

эртний бурханы шашны судалгаа Мэйжигийн эрин үеийн дундаас хойш буюу өнгөрсөн зууны эцэст эхэлсэн юм. Эдгээр судалгааны ачаар янз янзын дэгийг үүсгэгчдээс гадна юуны түрүүн бурханы шашны үндэслэгч буйг мартсан хүмүүсийн өмнө Бурхан Гаутамагийн яруу тод гэрэлт дүр тодорсон билээ. Махаянагаас өөр юу ч мэддэггүй байсан хүмүүсийн өмнө Бурхан багшийн эмх цэгцтэй сургаал тэр чигээрээ тодорсон юм. Эдгээр судалгаа одоохондоо цэвэр эрдэм шинжилгээний шинж чанартай, бурханы шашныг цоо шинээр өрнүүлэн хөгжүүлээгүй боловч бурханы шашны тухай япончуудын мэдлэгийг шинэчлэн баяжуулахад томоохон үүрэг гүйцэтгэж байгаа бүлгээ. Бидний үзэж байгаагаараа энэ нь Японы бурханы шашны хөгжлийн түүхэнд гуравдахь чухал үе нь юм.

## БУРХАН БАГШИЙН СУРГААЛ УЛАМЖИЛЖ ИРСЭН ТҮҮХ

Бурханы шашин нь Шагжамунийн 45 жилийн турш номлосон сургаал зарлигийн үндсэн дээр бүтсэн шашин юм. Тиймээс Шагжамунийн айлдварууд бурханы шашинд маргашгүй нэр хүндтэй байдаг бүлгээ. Хэдийгээр бурханы шашинд 84 мянган сургаал номлол, олон янзын дэг буй боловч, нэг нь ч гэсэн Шагжамунийн номлолоос үл зөрнө. Сургаалыг олон боть ном сударт бичиж, тэмдэглэж үлдээжээ. Тэдгээр номын аймгийг "Ицезин", "Дацанзин" (японоор "Иссайкё", "Дайзокё" гэнэ) гэдэг юм.

Шагжамуни номлол сургаалдаа бүх хүмүүс эрх тэгш байх ёстойг айлдсан билээ. Тэрбээр энгийн, хүн бүрт ойлгомжтой хэлээр ярьдаг байжээ. Амьсгаа хураатлаа буюу 80 нас хүртлээ тэрбээр аль болох олон хүнийг аврахын тулд тасралтгүй номлосоор байжээ.

Шагжамуни таалал төгссөний дараа шавь нар нь сургаалыг яг багшаасаа сонссоноороо залгуулан номлож байв. Гэвч айлдсан сургаалыг нь амаар дамжуулахдаа буруу зөрүү сонсох, багшийнхаа айлдсаныг буруу тогтоох зэрэг тохиолдол гарч болзошгүй байжээ. Гэтэл Шагжамунийн айлдваруудыг яг тэр чигээр нь уламжлан дамжуулах ёстой байсан юм.

Бурхан багшийн сургаалыг хэн байхаас үл шалтгаалан хүн бүрт хүргэх шаардлагатай байлаа. Эдгээр сургаалыг огтхон ч гуйвуулалгүй хойч үедээ дамжуулахын тулд мэргэн буурлууд хуран чуулж бүх сургаалыг эмх цэгцтэй болгож эхэлсэн юм. Энэхүү чуулган "Кэцзю" хэмээн алдаршсан билээ. Тус чуулганд олон арван өвгөн буурал лам цугларсан аж. Лам бүр багшаасаа сонссоноор сургаалуудыг дэлгэрэнгүй айлдаж

гарчээ. Эдгээр сургаалыг дэлгэрэнгүй задлан шинжилж, алдаа мадагтай эсэхийг шалгаж байлаа. Эл их ажил хэдэн сарын турш үргэлжилжээ. Энэ нь мэргэн буурлууд Шагжамунийн сургаалыг хойч үедээ үнэн зөв өвлүүлэхийн тулд юутай ухамсартай хандсаныг гэрчилнэ. Эмхэлж цэгцэлсэн айлдваруудыг ном сударт тэмдэглэж, түүн дээрээ хожим нь бурханы шашны зүтгэлтнүүдийн тайлбаруудыг нэмсэн аж. Эдгээр тайлбарыг утгачилвал "Эрэгцүүлэл" гэж нэрлэнэ. Бурхан багшийн айлдварууд, эрэгцүүлэлүүд, бурханы шашны лам хуврагуудын дэг жаягийг Типитака буюу "Гурван аймаг сав" хэмээдэг. "Гурван аймаг сав" нь Сутга-питака буюу "Судрын аймаг сав", Виная-питака буюу "Винайн аймаг сав", Абхидхарма-питака буюу "Авидармын аймаг сав" юм.

Одоо бүрэн бүтнээр уламжлагдан ирсэн пари хэлээр бичигдсэн судар болно. Пари хэлнээ гурван сан хэмээн алдаршсан судар уламжлагдан, бурхан шашинт эл улсын хамтын шүтээн судар болж чухал үүрэг хариуцлагаа гүйцэтгэж байгаа юм.

Домгийн дагуу бурханы шашин Хятадад манай эриний 67 онд буюу сүүлийн Хан улсын эзэн хаан Мин-дигийн ноёрхлын үед дэлгэрч эхэлсэн гэх боловч үнэн хэрэгтээ түүнээс хойш бүхэл бүтэн 84 жилийн дараа, өөрөөр хэлбэл 151 онд мөн улсын Хуан-ди эзэн хааны үед анх удаа бурханы шашны судрыг хятадаар орчуулсан юм. Тухайн үед энэтхэгт их хөлгөний бүлэг нэгэнтээ бий болсон ч хятад улсад эхэн үеийн бурханы судар болон их хөлгөний судар ялгаагүй уламжлагдан ирсэн байна. Түүнээс янагш бурханы шашны ном судрыг орчуулах ажил 1700 гаруй жилийн турш үргэлжилсэн юм. Орчуулсан судрын тоо 5586 боть бүхий 1440 ном болсон юм. Вэй улсын үеэс эхлэн бурханы шашны ном судрыг нэг газар хадгалж хамгаалахыг оролдож байсан аж. Гэвч

тэдгээрийг хэвлэх ажил Хойт Сүн улсын үеэс эхэлсэн билээ. Түүнээс хойш бурханы шашны номын тоонд хятадын бурханы шашны зүтгэлтнүүдийн бүтээлийг оруулдаг болсон юм. "Типитака" хэмээх нэр бурханы шашны ном судрын чуулганы агуулгад нийцэхээ больж Суй улсын үед бурханы шашны судрын чуулганыг "Ицезин" (япон нэр нь "Иссайкё"), Тан улсын үед "Дацанэин" (япон нэр нь Дайзокё) хэмээн тус тус нэрлэдэг болсон билээ.

VII зуунд бурханы шашин Төвдөд нэвтэрчээ. IX-XI зуунд ойролцоогоор 150 жилийн турш бурханы шашны ном судрыг төвд хэлээр орчуулжээ. Энэ хугацаанд бараг бүх ном судрыг орчуулсан юм.

Түүнээс гадна Бурхан багшийн айлдвар, номлолыг солонгос, япон, шри-ланка, монгол, камбожи, турк зэрэг дорнодын хэлээр очуулаад зогсохгүй латин, франц, англи, герман, итали зэрэг Европын олон хэлээр орчуулжээ. Тиймээс одоо Бурхан багшийн сургаал даян дэлхийд түгэж дэлгэрсэн гэж хэлэхэд хэтрүүлсэн болохгүй юм. Харин түүний агуулгын тухайд гэвэл бурханы шашин хоёр мянга гаруй жилийн түүхтэй, тэгээд ч түүний ном судар нэг түм гаруй боть учир, "Дайзокё"-гийн бүрэн орчуулга байдаг ч гэсэн бурхан багшийн айлдваруудын жинхэнэ утга учрыг ухаарч ойлгоход хэцүү билээ. Тиймээс бид бүхний шашин шүтлэгт түшиг тулгуур болж чадахуйц "Дайзокё"-гийн хамгийн чухал чухал хэсгийг шилж сонгох шаардлага урган гарсан юм.

Бурханы шашинд Шагжамунийн айлдварууд өчүүхэн ч гуйвашгүй нэр хүндтэй билээ. Тиймээс түүний сургаал бид бүхний амьдралтай аль болохоор нарийн нягт холбоотой, аль болохоор ойр дотно байх ёстой юм. Эс тэгвээс нэг түм гаруй боть бүхий ном судар бидний сэтгэлийг үл хөдөлгөнө. Тиймээс түүний сургаалыг ямагт бидний гар дор байдаг номын

хэлбэртэй болгон ерөнхийлөн товчлох шаардлага гарсан юм. Хэдийгээр энэ ном хэлбэрийн хувьд авсаархан боловч өрөөсгөл утгатай байх ёсгүй бөгөөд бурханы шашны бүх баялаг ном судрыг хамарсан байх шаардлагатай. Энэ номын уг бүрийг хүн бүхэнд ойлгомжтой, оновчтой, жирийн ярианы хэлээр бичсэн байвал зохино.

Энэ номыг чухамхүү ийнхүү буяныг санаж, зүрх сэтгэлийн угаас урган гарсан хүсэл эрмэлзэлд хөтлөгдөн бүтээсэн юм. 2000 гаруй жилийн турш үл ширгэн урсаж буй Шагжамунийн сургаалын их далайгаас эх авсан "Дацанзин" хэмээх их мөрний хүчит урсгалаас эл ном утга санаагаа уудлан авсан юм. Энэ бол төгс төгөлдөр болж бүтсэн ном гэж хэлж болохгүй нь тодорхой. Шагжамунийн айлдваруудын утга санаа хэмжихийн аргагүй гүн гүнзгий, түүний буян хязгааргүй учир хэнбугай ч тэдгээрийг хэмжиж үнэлэн цэгнэж чадахгүй. Бид, энэ номыг хэвлэх бүрдээ засан залруулж, эцсийн эцэст урьд урьдахаасаа илүү бүрэн дүүрэн, үнэнд улам ойр болно гэдэгт найдаж байна. Тийм ч ном байх ёстой юм.



## **"БУРХАН БАГШИЙН СУРГААЛ" ХЭМЭЭХ ЭЛ НОМ БҮТСЭН ТҮҮХ**

Энэхүү "Бурхан багшийн сургаал" нь 1925 онд Муан Кизугийн толгойлж байсан "Бурхан багшийн сургаалын шинэ түүх"ийг түгээн дэлгэрүүлэх Нийгэмлэгээс эрхлэн хэвлэсэн "Бурхан багшийн сургаалын шинэ түүх"-ийг засан залруулж, шинээр эмхэтгэсэн хэвлэл юм.

"Бурхан багшийн сургаалын шинэ түүх"-ийн анхны хэвлэлийг Шүүгакү Ямабэ, Чизэн Аканума зэрэг профессорууд таван жилийн турш бурханы шашны олон эрдэмтэн мэргэдтэй хамтран ажилласны үр дүнд эмхэтгэсэн байна.

Бурханы шашныг сурталчлах нийгэмлэг, юуны түрүүн Муан Кизу болон энэхүү анхны хэвлэлийг эмхэтгэхэд оролцсон бүх эрдэмтэн мэргэдэд гүн гүнзгий талархал дэвшүүлж байна.

1926 оноос эхлэн Шовагийн эрин үед "Бурхан багшийн сургаалын шинэ түүх"-ийг сурталчлан дэлгэрүүлэх Нийгэмлэг "Бурхан багшийн сургаалын хялбаршуулсан хэвлэл" номыг хэвлэж, Япон орон даяар түгээн тараасан юм. 1934 оны зуны эхэн сард Номхон далайн орнуудын бурханы шашинт залуусын их хурал Япон улсад хуралдахад энэ их хуралд зориулсан нэгэн арга хэмжээ болгож бүх Японы бурханы шашинт залуусын холбооноос "Бурхан багшийн сургаалын хялбаршуулсан хэвлэл"-ийг Д. Годдардын тус дэмжлэгээр "Бурхан багшийн сургаал" нэртэйгээр англи хэлээр хэвлэсэн юм.

1962 онд Америк тивд бурханы шашин дэлгэрч эхэлсний 70 жилийн ойд зориулж Мицүтоё пүүсийг үндэслэгч Эхан

Нумата "Бурхан багшийн сургаал"-ыг англи хэлээр хэвлэжээ. 1965 онд Нуматагийн хөрөнгөөр бурханы шашны Нийгэмлэг үүсч, "Бурхан багшийн сургаал"-ыг даян дэлхийд түгээн дэлгэрүүлэхээр шийдсэн юм.

Энэхүү шийдвэрийн дагуу 1966 онд "Бурхан багшийн сургаал"-ыг дахин хянах, шинээр эмхэтгэх тусгай хэсэг байгуулсан байна. Энэ хэсгийн бүрэлдэхүүнд Казүёши Кино, Шүүюү Канаока, Зэнно Ишигами, Шинко Сазки, Кодо Мацунами, Шуузюн Бандо, Такэми Такасэ нар орсон юм. Фумио Масутани, Н.А Уодделл, Тошисүкэ Шимизү болон бусад эрдэмтэн мэргэд тэд нарт тусалжээ. Ийнхүү бүхэлд нь шинэчлэн хянаж зассан "Бурхан багшийн сургаал"-ыг япон хэлээр зэрэгцүүлсэн англи орчуулгын хамт хэвлэжээ.

1972 онд тус "Сургаал"-ын буруу ташаа зүйлийг нөхөн залруулахын тулд Шүүюү Канаока, Зэнно Ишигами, Шууюү Ханаяма, Кансэй Тамура, Такэми Такасэ нар түүнийг дахин хянаж "Бурхан багшийн сургаал"-ыг англи хэлээр хэвлэжээ.

1973 онд "Бурхан багшийн сургаал"-ын япон хэл дээрх хэвлэлийг бүхэлд нь дахин хянаж, үсгийн алдаа мадагийг засч, нэмэлт оруулж, "Бурхан багшийн сургаал"-ыг япон хэлээр шинээр хэвлэсэн аж.

1974 онд буруу онож орчуулсан үгс, хэллэгийг засч залруулахын тулд Кодо Мацунами, Шуузюн Бандо, Шинко Сазки, Дюю Токунага, Кансэй Тамура, Шууюү Ханаяма нар, Р.Стейнер нарын туслалцаатайгаар "Бурхан багшийн сургаал"-ын англи эхийг бүхэлд нь дахин хянан засч, япон хэлээр хэвлэсэн "Бурхан багшийн сургаал"-тай хамт хэвлэжээ. Ийнхүү "Бурхан багшийн сургаал"-ын япон эхийг тулган хянасан англи орчуулгын хамт хэвлэсэн байна. 1978, 1980 онуудад дээр нэрийг нь дурьдсан хянан тохиолдуулагчид

болон Шигэо Камата, Ясуаки Нара нарын оролцоотойгоор хянан тохиолдуулж, 2001 онд Кэнэс Танака, Ёнэзава Ёшиясу, Ватанабэ Шоко, Маэда Сэнгаку(Ахлах редактор) нар нэмэгдэж хянан тохиолдуулсан. 2013 онд Бурханы шашныг сурталчлах нийгэмлэг нь хувь нийлүүлсэн байгууллагаасаа буяны байгууллага болсонтой болсонтой холбоотойгоор Маэда Сэнгаку(Ахлах редактор), Ишигами Зэно, Кимура Киётака, Кэнэс Танака, Такэмура Макио, Ясуаки Нара, Ёшимизу Чизуко, Ёнэзава Ёшиясу, Ватанабэ Шоко гэсэн гишүүдтэйгээр “Бурхан багшийн сургаал”ыг хянан тохиолдуулах албыг байгуулж, улам сайжруулахын тулд жил бүр уулзалт зохион байгуулдаг. Энэхүү идэвхи зүтгэл цаашид ч үргэлжлэх болно.

“Бурхан багшийн сургаал” номыг монгол хэлээр Намбарын Энхбаяр орчуулав. Очирбатын Дашбалбар, Жамбалын Хатанбаатар нар хянан тохиолдуулав. Дожоогийн Цэдэв, Канаока Хидэро нар тулгуур хийж нягтлан уншив.

1991 оны хавар.

2017он, Такэмура Макио багш ерөнхий редактор ажиллав.

## СЭДВИЙН ЗААЛТ

<i>Амьдрал</i>	Хуу -дас	мөр
Амьдралын утга учир .....	5	12
Бодит ертөнц .....	104	1
Зөв тэгш амьдрал .....	249	14
Амьдралыг буруу үзэх үзэл .....	48	17
Амьдралын тухай зөв төсөөлөл .....	45	1
Өрөөсгөл амьдрал .....	61	20
Төөрөлдөгсдөд зориулах нь .....	135	10
Хүний амьдрал (сургаал домог) .....	97	10
Хэрэв амьдралын зугаа цэнгэлийг үтэр тонилгон хөөвөл (сургаал домог) .....	96	18
Өвгөн, өвчтөн, талийгаач гурав юуг зааж сургана вэ (түүх) .....	100	16
Үхлээс зайлж үл болно (түүх) .....	101	16
Энэ хорвоо ертөнцөд үл биелж бүтэх Таван зүйл .....	52	12
Энэ ертөнцийн дөрвөн үнэн .....	53	1
Төөрөгдөл, гэгээрлийн аль аль нь сэтгэлээс үүднэ .....	53	16
Жирийн хүний бүтээхэд бэрх хэцүү боловч ихээхэн үнэ цэнэ бүхий 20 зүйл .....	142	7
<i>Итгэл</i>		
Итгэл бишрэл бол гал мөн .....	192	5
Итгэл бишрэлийн гурван тал .....	193	15
Итгэл нь гайхамшиг .....	194	19

	Сэдвийн Заалт	
	Хуу -дас	мөр
Итгэл нь чин сэтгэлийн илрэл мөн.....	194	1
Сохор хүмүүс зааныг таньж мэдэхэд хэцүү байдагтай адил үнэнийг олоход бэрх (сургаал домог).....	80	12
Бурхан багшийн зөв сургаал нь Бурхан багшийн мөн чанарыг харуулна (сургаал домог) .....	83	7
Бухан багшийн мөн чанар хорвоогийн шунал тачаалын дор нуугдмал буй .....	78	23
Эгэлзэл нь итгэл бишрэлд саад бэхшээл болно.....	95	9
Бурхан багш- эцэг, хүмүүс- Түүний үр хүүхэд мөн.....	37	24
Бухан багшийн оюун ухаан далай лугаа адил өргөн дэлгэр, гүн гүнзгий юм .....	36	7
Бурхан багшийн сэтгэл агуу их нигүүлсэнгүй, энэрэнгүй үзлээр дүүрэн.....	15	1
Бурхан багшийн энэрэнгүй нигүүлсэнгүй сэтгэл мөнх оршино.....	16	8
Бухан багш бие махбодгүй.....	14	1
Бурхан багш бүхий л амьдралынхаа турш номлож байсан .....	24	15
Бурхан багш хүмүүсийг аврахын тулд үхлийг үзүүлсэн .....	24	15
Бурхан багш сургаал домгийг ашиглаж.	19	15
Хүмүүсийг төөрөгдлөөс ангижруулсан .	20	13
Гэгээрлийн ертөнц.....	267	14

Сэдвийн Заалт

	Хуу -дас	мөр
Бурхан багш, Ном, Лам хуврагуудын өлмийд мөргөмүй .....	190	18
Сахилаа мөрдөх, сэтгэлээ төвлөрүүлэх, Ухаантай үйл бүтээхийг хэрхэн сурах тухай.....	175	6
Найман зөв зам мөр .....	178	2
Гэгээрэх зургаан зам мөр .....	180	13
Дөрвөн янзаар биеэ зөв авч явах нь.....	179	15
Дөрвөн зөв үзэл.....	179	7
Гэгээрүүлэх таван хүч .....	180	6
Сэтгэлийн дөрвөн хязгааргүй байдал.....	183	20
Амьдралын утга учрыг ухаарсан хүмүүс.....	43	11
Хүний үхэл, түүний оршихын мөнх бус чанар .....	12	23
Бурхан багшийн нэр алдрыг давтсан хүмүүс Түүний жаргалтай оронд мэндэлдэг .....	121	4
Өөрөө гал шиг дүрэлзэж бай, өөрөө өөртөө л найдаж яв .....	10	16
<i>Сэтгэл санаагаа төгөлдөржүүлэх нь</i>		
Хүн бүр өөрт нь чухамхүү юу чухлыг ойлгох хэрэгтэй (сургаал домог) .....	161	10
Анхны алхам хийхээсээ эхлээд хянуур болгоомжтой бай .....	142	2
Юу эрж хайж байгаагаа бүү март (сургаал домог) .....	163	6

	Сэдвийн Заалт	
	Хуу -дас	мөр
Аливаа юманд амжилт олохын тулд ихээхэн зовж зүдэрдэг (түүх).....	169	22
Хичнээн олон ойчсон ч, дахин босч, хөл дээрээ зогс (түүх).....	185	16
Нөхцөл байдалд сэтгэлийнхээ амар Амгаланг бүү эвдүүл (түүх).....	132	7
Үнэнийг эрэн хайж буй хүн харанхуй өрөөнд гэрэлтэй орж буй хүн лүгээ адил.....	44	3
Хүн амьдралын бүх юмнаас сургаалыг олж хардаг (түүх).....	173	6
Хүний үйлдлийг сэтгэл удирдана.....	129	22
Сургаалын гол нь сэтгэлээ төгөлдөр-жүүлэхэд оршино.....	11	14
Юуны түрүүн сэтгэлээ хянаж удирдах Хэрэгтэй .....	226	1
Хэрэв сэтгэлээ хянан удирдаж чадвал ...	130	4
Сэтгэлийн янз янзын байдал (домог үлгэр).....	126	9
Сэтгэл бол өөрийн "би" бус .....	50	15
Сэтгэлийн хөдөлгөөнд бүү автаж захирагд.....	10	21
Сэтгэлийн хөдөлгөнөө дийлж бай.....	165	3
Сэтгэлийнхээ эзэн бол.....	11	22
Бүх нүглийн эх булаг нь бие, хэл, сэтгэл гурав юм.....	93	3
Сэтгэл, үгсийн хоорондын холбоо .....	133	22
Энэхүү бие цаг зуурын чанартай (түүх).	153	9
Энэхүү бие бузраар дүүрэн.....	139	20

## Сэдвийн Заалт

	Хуу -дас	мөр
Юуг ч хүчтэй үл хүс .....	10	21
Бие, хэл, сэтгэлээ цэвэр ариун байлга....	131	20
Сэтгэлээ төгөлдөржүүлж, аливаа юманд хэм хэмжээг баримталж бай (түүх) .....	184	22

### *Зовлон зүдүүр*

Ямар нэгэн юманд дадаж дассан сэтгэл зовлон зүдүүрийг буй болгоно .....	46	17
Зовлон зүдүүрийг хэрхэн зайлуулах нь .	13	11
Төөрөлдөх нь гэгээрэхэд хүрэх үүд хаалга юм .....	64	7
Төөрөгдлөөс хэрхэн салж ангижрах вэ ..	124	1
Орчлонгийн шунал тачаалын голыг унтрааваас сэрүүн тунгалаг гэгээрлийг олно.....	151	19
Хүсэл шунал бол төөрөгдлийн учир шалтгаан мөн .....	91	13
Шунал хүсэл нь цэцэгсийн сүүдэрт нуугдаж буй хорт могой лугаа адил хэмээн бодож яв.....	91	22
Галд автсан байшинд бүү дас (сургаал домог) .....	20	5
Хүсэл нь алдаа мадагийн учир шалтгаан юм.....	126	1
Эл орчлон тэр аяараа галд автжээ .....	88	19
Хүн нэр алдар, эд баялгийн хойноос хөөцөлдвөөс өөрийгөө л шатаана.....	127	10



Хүн нэр алдар, хайр дурлалын хойноос хөөцөлдвөөс өөрийгөө үхдийн зам руу хөтлөнө .....	127	17
Ухаантай, мунхаг хоёр хүний мөн Чанар.....	143	4
Мунхаг хүн, үйлдсэн нүглээ анзаардаггүй (сургаал домог) .....	150	15
Мунхаг хүмүүс гагцхүү үр дүнгээр нь тооцож бусдад атаархана (сургаал домог) .....	151	1
Мунхаг хүмүүсийн тухай (сургаал домог) .....	157	18
<i>Өдөр тутмын амьдрал</i>		
Өглөг өргөмөгцөө өргөснөө март .....	182	3
Эд өмчгүй хүний өргөх долоон өргөл Барьц.....	182	6
Хэрхэн яаж баяжих вэ? (түүх) .....	156	7
Хэрхэн яаж жаргах вэ? .....	141	18
Тусыг хэзээ ч бүү мартаж бай (түүх) .....	148	6
Хүний янз янзын зан араншин.....	95	9
Өш хонзон санасан хүн азгүй явдалтай Учирна.....	141	5
Хэрхэн яаж гомдлыг цайруулах вэ? (түүх) .....	245	23
Бусдын шүүмжлэлийг зүрх сэтгэлдээ хэтэрхий ойрхон бүү тусга (түүх).....	130	18
Хүн гагцхүү хувцас хунар, хоол хүнс, орон гэрийн төлөө амьдардаггүй.....	218	20

## Сэдвийн Заалт

	Хуу -дас	мөр
Хувцас хунар, хоол хүнс бол зугаа цэнгэлийн тулд бус .....	125	1
Хоол ундаа хандах нь.....	221	16
Хувцас хунарт хандах нь.....	220	19
Унтаж нойрсоход хандах нь .....	222	12
Халуун дулаан, хүйтэн нойтонд хандах нь .....	221	21
Өдөр тутмын амьдралд хандах нь .....	220	1

### *Аж ахуй*

Эд агуурсыг ёс зүйнх нь дагуу ашиглах хэрэгтэй (түүх).....	234	15
Өмч хөрөнгө хүнд мөнх үл ноогдоно.....	234	5
Гагцхүү өөрийнхөө төлөө өмч Хөрөнгөө бүү хадгал .....	236	22
Хэрхэн яаж баяжих вэ (түүх) .....	156	7

### *Гэр бүл*

Гэр бүл бол түүний бүх гишүүдийн сэтгэлээрээ харилцдаг орон газар мөн ...	231	20
Гэр бүлийг эвдэн сарниулдаг Үйлдлүүд.....	226	21
Эх эцгийнхээ агуу их ачийг хэрхэн яаж хариулах вэ.....	231	14
Эцэг эх, үр хүүхдийн хоорондын Харилцаа .....	227	20
Эр нөхөр, эхнэр хоёрын хоорондын Харилцаа .....	228	12
Эр нөхөр, эхнэр хоёр нэг л сүсэг		

	Сэдвийн Заалт	
	Хуу -дас	мөр
бишрэлтэй байх ёстой (түүх) .....	235	16
<i>Хуврагийн зам мөр</i>		
Ламын хувцас өмсөж, маань уншсанаар лам болохгүй.....	211	3
Лам хувраг нь сүм хийд болон сүм Хийдийн бүх бурхан шүтээн, эд агуурсыг өвлөн авагч бус .....	208	1
Ховдог хомхой сэтгэлтэй хүн жинхэнэ лам болж үл чадна .....	208	5
Жинхэнэ лам хуврагийн амьдрал .....	210	1
<i>Нийгэм</i>		
Нийгмийн ач холбогдол .....	240	17
Нийгмийн бодит байдал.....	104	1
Олон төрлийн байгууллага .....	241	1
Жинхэнэ нөхрийн холбоо .....	241	11
Харанхуйг арилгагч гэрэл.....	239	8
Энх амгалан, эв найрын харилцаа холбоо.....	242	1
Аливаа хамт олны дотор энх амгалан, эв найрыг тогтоох арга.....	243	12
Лам хуврагуудын үлгэр жишээ холбоо..	242	7
Бурхан багшийг дагагчдын нийгмийн туйлын зорилт.....	251	2
Хэв журам эвдэгчид өөрсдөө үхэж үрэгдэнэ (сургаал домог).....	149	17

## Сэдвийн Заалт

	Хуу -дас	мөр
Бусдад атаархаж, хэрэлдэж маргагсад Өөрсдөө үхэж үрэгдэнэ (сургаал домог) .....	149	17
Ахмад буурлуудыг хүндэтгэж яв (түүх) .....	143	21
Багш, шавь нарын барилдлагаа.....	228	1
Нөхөрлөл найрамдлын дүрэм журам .....	228	21
Эзэн хөлсний ажилчдын хоорондын харилцаа .....	230	9
Найз нөхөр сонгох зам мөр .....	229	6
Гэмт хэрэгтнүүдэд хандах нь.....	237	11
Багш нарт хандмуй .....	212	12

# **САМГАРЬД ҮГСИЙН ТАЙЛБАР**

## **АНАТМАН (“Би” бээр байхгүй)**

Энэ нь бурханы шашны хамгийн чухал ухагдахууны нэг юм. Бурханы шашны дагуу гэрэлт ертөнцөд мөнх орших юм байхгүй учир хорвоод аливаа юм өөрийн мөн чанаргүй юм.

## **АНИТЪЯ (аливаа юм хувиран өөрчлөгддөг чанартай)**

Энэ нь Бурханы шашны хамгийн чухал ухагдахууны нэг юм. Энэ ухагдахууны дагуу хорвоо ертөнцөд бүх юм хувиран өөрчлөгдөх бөгөөд байнга, тогтмол орших юм байхгүй аж. Аливаа амьд амьтан эрт орой хэзээ нэгэн цагт үхэх ёстой, энэ нь зовлонгийн учир шалтгаан болж байдаг юм. Гэвч хөгжил дэвшил, нөхөн төрөх нь мөн адил байнгын өөрчлөлт хувиралтын үр дагавар мөн учир эл олон үзэлд гутрангуй хандах хэрэггүй.

## **БОДХИСАТВА (гэгээрэхийг ХҮСЭН ТЭМҮҮЛСЭН ХҮН)**

Анх Гаутама Сиддарта гэгээрэхээсээ өмнө ийм нэртэй байжээ. Махаяна буюу Их хөлөгний шашин үүссэний дараа гэгээрэхийг хүсэн тэмүүлсэн болгоныг ийнхүү бодхисатва буюу бодьсад гэж нэрлэх болсон аж. Сүүлдээ амьд амьтан бүрт дээд язгуурын нигүүлсэнгүй сэтгэлд хөтлөгдөн хандаж, гэгээрүүлэхийг оролдож буй хүмүүсийг ч ингэж нэрлэдэг болжээ. Хамгийн их алдаршсан бодьсад нарыг дурьдвал: Авалокитешвара буюу Хонсим бодьсад, Кшитигарбха, Ман жушри нар юм.

## **БУДДА (Гэгээрч төгс нөгчсөн)**

Анх бурханы шашныг үндэслэгч Гаутама Сиддарта (Шагжамуни)-г ингэж нэрлэдэг байжээ. Учир нь тэрбээр 35 насандаа буюу одоогоос 2500 орчим жилийн өмнө Энэтхэгт гэгээрсэн аж. Өөрсдийн хамаардаг дэг, чиглэлээс үл шалтгаалан бурханы шашинтан бүрийн эцсийн зорилго нь Бурхан болоход оршино. Бурхан болох аргууд нь хоорондоо

ялгаатай.

учир бурханы шашин янз янзын дэг, сургуульд хуваагдсан байдаг. Махаяна буюу Их хөлөгний шашинд түүхэн хувь хүн болох Бурхан багшаас гадна Ами табха буюу Аминдава Махавайрочана буюу Махабаярзана, Вайсажагуру нарын зэрэг бэлгэдэл бүхий олон Буддаг хүлээн зөвшөөрч, тахин шүтдэг. Амар жаргалтай оронд мэндэлсэн хүн бүр бурхан болдог гэсэн "Зол жаргалтай орны онол"-ын нөлөөн дор Япон улсад талийгаач болгоныг Бурхан буюу японоор "Хотоке хэмээн нэрлэдэг.

### **ДХАРМА (Зөв ном сургаал)**

Энэ нь Ялж төгс нөгчсөнийг номлодог сургаал юм. Бурхан багшийн сургаалд гурван аймаг сав буй. Үүнд: Сударын аймаг сав (Бурхан багшийн айлдвар, яриа), Винайн аймаг сав (Бурхан багшийн тогтоосон дэг сахилга), Авидармын аймаг сав (Сударын болон Винайн аймаг савын ном сударт хожмын бурханы шашныг судлагчдын туурвисан тайлбар эргэцүүлэлүүд) эдгээр багтана. Энэ гурван аймаг савыг нийтэд нь Типтака хэмээнэ. Дхарма буюу Дарма нь бурханы шашны гурван эрдэнийн нэг нь юм.

### **КАРМА (Үйл)**

Хэдийгээр анх энэ үг " үйл " гэсэн жирийн утгатай байсан боловч учир шалтгааны онолтой холбоотойгоор урьд өмнө үйлдсэн янз бүрийн үйлийн үр дүнд хуран хуримтлагдсан нэг ёсны нөөц хүч хэмээн тооцогдох болсон юм. Тодруулвал, хүний үйл бүр сайн, муугаасаа шалтгаалан ирээдүйд сайн эсвэл муу үр дүнд хүргэнэ. Улмаар хүний ирээдүйд нөлөөлөх энэхүү хүчийг карма (үйлийн үр) хэмээн нэрлэдэг болжээ. Хэрэв сайн үйл бүтээвэл буян хурж, түүний нөөц хүч, тэр үйлийг үйлдсэн хүний ирээдүйд сайнаар нөлөөлдөг гэж үзнэ. Хүний үйлс: бие, хэл болон сэтгэлийн гэж гурав хуваагддаг.

## **МАХАЯНА (Их хөлөг)**

Бурханы шашны түүхэнд МахаянаХинаяна хэмээх хоёр том урсгалыг тэмдэглэсэн буй. Махаяна буюу Их хөлөгний сургаал Төвд, Хятад, Солонгос, Япон, Монгол болон бусад хойд зүгийн орнуудад, Хинаяны буюу Бага хөлөгний сургаал Бирм, Шри-Ланка (Цейлон), Тайланд болон урд зүгийн орнуудад түгэн дэлгэрчээ. Махаяна хэмээх нь энэхүү ертөнцөд төрж, үхэж буй бүх амьд амьтны зовлон зүдүүрийг багтааж, тэдгээрийг хооронд нь өчүүхэн бээр ялгалгүй цугааранг гэгээрүүлэхээр тээж чаддаг "Их хөлөг" гэсэн утгатай үг юм.

## **НИРВАНА (Бүрэн амарлингуй байдал, дээд зэргийн баяр цэнгэл)**

Махчилвал "Унтраах, бөхөх" гэсэн үг. Энэ нь сэтгэл юүгээ төгс төгөлдөр болгож, зөв оюун ухааны үндсэн дээр дотоод бясалгал үйлдсэний ачаар хүний бүх бузар, шунал тачаал бүрмөсөн замхран арилсны дараах байдал юм. Ийм байдалд хүрсэн болгоныг бурхан гэнэ. Гаутама Сиддарта 35 настай байхдаа ийм нөхцөлд хүрч бурхан багш болжээ. Гэвч одоо Тэрбээр бүрэн амарлингуй байдалд гагцхүү амьсгаа хураасны дараа хүрсэн гэж үзэж байгаа юм. Учир нь хүний бие махбод амьдарч байгаа бол түүний бузар мөн адил оршсон хэвээр байдаг аж.

## **ПАЛИ (хэл)**

Энэ нь Хинаяны буюу Бага хөлөгний сургаалын хэл юм. Бурханы шашны хамгийн эртний ном судрыг энэ хэлээр тэмдэглэн бичсэн гэж үздэг. Энэ бол самгарьд хэлний нэг аялгуу учраас энэ хоёр хэлний хооронд төдийлөн их ялгаа байхгүй. Үлгэрлэвэл, самгарьдаар Дхарма гэдэг бол палигаар Дхамма, самгарьдаар Нирвана бол, палигаар Ниббана юм.



## **ПАРАМИТА (цаад талын эрэгт хүргэдэг Хэрэгсэл)**

"Цаад талын эрэгт хүргэдэг хэрэгсэл" нь Бурхан багшийн ертөнцөд хүрэхийн тулд хүний хэрэглэдэг арга хэрэгсэл билээ. Өглөгч зан, ёс суртахуун, тэвчээр хатуужил, зориг, бясалгах чадвар, оюун ухаан зэрэг хүнийг төрөх, үхэхийн ертөнцөөс гэгээрэхийн ертөнцөд авчирдаг 6 парамит буюу барамид буй гэж үздэг. Японы хавар, намрын Хиган хэмээх долоо хоногууд бурханы шашны энэхүү ухагдахуунаас үүдэн гарчээ.

## **ПРАЖНЯ (Оюун билиг)**

Энэ нь 6 барамидын нэг нь билээ. Энэ бол хүний амьдралд зөв хандах, үнэнийг төөрөгдлөөс ялгах сэтгэлийн чадвар юм. Энэхүү чадварыг олсон хүнийг бурхан багш хэмээнэ. Тиймээс энэ бол ердийн хүний ухаанаас ялгаатай хамгийн ариун тунгалаг, гэгээрсэн оюун юм.

## **САНГХА (Бурханы олон шавь хуврагууд)**

Бурханы шашны лам хуврагуудад гэлэн, гэлэнмаа тодохой сахил хүртэж тангараг өргөсөн хүмүүс тооцогдоно. Анх тэдгээрийн тоонд гагцхүү бадар барьдаг гэлэн, гэлэнмаа нар ордог байжээ. Хожим нь Махаяна буюу Их хөлөгний сургаал хөгжиж дэлгэрэхэд Сангха буюу Сангагийн тоонд гэлэнгүүдээс гадна бодьсадын зиндаанд хүрэхийг хүссэн бүх хүн тооцогдох болсон аж. Энэ нь бурханы шашны гуррван эрдэнийн нэг юм.

## **САНСКРИТ (хэл)**

Энэ бол Энэтхэг-Европын хэлний аймагт багтдаг эртний Энэтхэгийн сонгодог бичгийн хэл юм. Түүнийг ведийн болон сонгодог санскрит буюу самгарьд гэж хуваадаг. Махаяны буюу Их хөлөгний сургаалын ном судрыг энэ бичгээр тэмдэглэсэн бөгөөд түүний найруулгыг даган бурханы шашны холимог санскрит гэдэг билээ.

## **САНСАРА (Дахин дахин төрөхийн гинжин хэлхээ)**

Энэ бол наракийн оршин суугч, бирд, амьтан, хүн, асур тэнгэр нар зэрэг зургаан ертөнцөд өнгөрснөөс өнөөдрийг дамжин ирээдүйд эцэс төгсгөлгүй үхэх төрөх давтагдахын нэр юм. Хүн гэгээрч эс чадваас энэхүү төрж үхэхийн тойрогт байнга эргэлдэхийн заяатай юм. Энэхүү тойргоос гарч чадсан хүнийг бурхан гэдэг.

## **ШУНЬЯТА (Хоосон чанар)**

Энэ нь бурханы шашны хамгийн чухал ухагдахууны нэг юм. Энэхүү ухагдахууны дагуу гэрэлт ертөнцөд аливаа юм мөн чанаргүй бөгөөд мөнх оршихгүй юм. Эд юмс учир шалтгааны нарийн холбоотой тул өөрийн мөн чанар бүхий байнга тогтмол орших юм байхгүй. Тийм учраас юм бүхэн мөн чанартай эсвэл юу ч мөн чанаргүй хэмээн аль алинд нь хатуу итгэж үл болно. Энэ ертөнцөд аливаа юмны орших нь харьцангуй бөгөөд үнэмлэхүй чанартай юм байхгүй билээ. Энэ бол Махаяны гэх Их хөлөгний сургааль буюу Пражнягийн судрын гол ухагдахуун юм.

## **СУТРА (Ариун хөлгөн судар)**

Бурхан багшийн номлолыг бичиж тэмдэглэснийг ингэж нэрлэдэг. Анх энэ үг эрдэм шинжилгээний ном, мэргэн үгсийн эмхэтгэлийн нэр байжээ. Сутра буюу судар нь Типитакийн нэг аймаг сав билээ.

## **ТХЕРАВАДА (Бага хөлөгний сургаал)**

Энэ бол өмнө зүгийн уламжлалын бурханы шашинтан нарын гаргадаг нэгэн ердийн дуу авиа юм. "Тхера" нь ахмад гэсэн үг. Энэ бол түүхийн үүднээс үзэхэд бурхан багшийн сургаалыг хатуу чанд баримталдаг нэг хэсэг ахмад лам нарыг төлөөлсөн ахмадуудын дэг юм. Тэд нарын эсрэг арай дэвшилттэй сэтгэдэг өөр нэгэн хэсэг лам байсан билээ. Хожим нь тэдний үзэл бодол махаяны хүрээнд хөгжиж дэгжсэн. Энэ бол хойд зүгийн уламжлал билээ. Ийм хагарал бүр бурханы шашны эхний үед, Бурхан багшийн таалал төгссөнөөс хойш хэдхэн зуун өнгөрсний дараа, тэр үед дэвшилттэй хэмээн тооцогдож байсан. Махадэва лам, Бурхан багшийн сургаалын таван аймгийг урьд өмнөхөөс арай чөлөөтэй номлож болно хэмээн үзэж эхлэхэд тодорсон юм. Эцсийн эцэст энэ зөрчил хоёр дэг болж хуваагдсанаар шийдвэрлэгдсэн юм. Хожим нь Махасангхикийн дэг Махаяны сургаалыг боловсруулсан билээ.

## **Типитака (Гурван аймаг сав)**

Энэ бол бурханы шашны ариун ном судрын гурван аймаг савын нэр Дармууд юм. Үүнд: Бурхан багшийн айлдвар, мэргэн сургаалыг эмхэтгэсэн Сударын аймаг сав, бурханы шашны лам хуврагуудын баримтлах ёстой эртний дэг сахилыг эмхэтгэсэн винайн аймаг сав, метафизикийн эрэгцүүлэлийг эмхэтгэсэн Авидармын аймаг сав эдгээр болно. Хожим нь Хятад, Японы бурханы шашны суут эрдэмтэн мэргэдийн бүтээлүүд бурханы шашны ном сударт багтан ордог болсон байна. Дхарма-г үз.

**БУРХАНЫ ШАШНЫГ СУРТАЛЧЛАХ**  
**"БУРХАН БАГШИЙН СУРГААЛ"**  
**НИЙГЭМЛЭГИЙН**  
**ТУХАЙ**

Бурханы шашныг сурталчлах Нийгэмлэгийн тухай ярихдаа "Мицүтоё" пүүсийг үндэслэгч Эхан Нуматагийн нэрийг дурьдахгүй өнгөрч болохгүй.

50 гаруй жилийн өмнө тэрбээр нарийн хэмжүүрийн багаж үйлдвэрлэдэг пүүс байгуулжээ. Эхэлсэн үйл хэрэг амжилттай байх эсэх нь тэнгэр, газар, хүн гурвын хоорондын зүй зохистой харилцаанаас, хүний төгс төгөлдөр чанар бол оюун ухаан, нигүүлсэнгүй сэтгэл, эр зориг гурвын хоорондын тэнцвэртэй зохицлоос шалтгаална гэдэгт хатуу итгэсэн тэрбээр шинэ технологийг боловсруулах, хүнийг төгс төгөлдөр болгох зорилт тавьжээ. Тэрбээр олон улсын энх амгалан байдал гагцхүү хүнийг төгс төгөлдөр болгосноор тогтоно, үүний тулд хамгийн сайн тохирох шашин нь бурханы шашин мөн хэмээн итгэдэг юм.

Тиймээс 50 жилийн турш пүүсээ удирдаж байхдаа тэрбээр бурханы шашныг сурталчлахын тулд бурханы шашны хөгжил, уран зураг, сургаалыг түгээн дэлгэрүүлэх, шинэчлэхэд ихээхэн хүч хөдөлмөр зарцуулж байжээ. 1965 оны 12 дугаар сард тэрбээр хөрөнгө гаргаж бурханы шашныг түгээн дэлгэрүүлэх бүх үйл ажиллагаагаа нэг байгууллагад төвлөрүүлж ингэснээр олон улсын энх амгалан байдлыг бэхжүүлэхэд өчүүхэн ч гэсэн өөрийн хувь нэмрийг оруулахыг эрмэлзжээ.

Ийнхүү Бурханы шашныг сурталчлах Нийгэмлэг хэмээх олон нийтийн байгууллага үүсчээ. Бурхан багшийн сургаалыг өргөн дэлгэр, гүн гүнзгий түгээн дэлгэрүүлж, газар дэлхий дээр бүх хүн дээд язгуурын оюун ухаан, дээд язгуурын нигүүлсэнгүй сэтгэлийн гэрэл гэгээгээр гийдэг байхын тулд яах ёстой вэ? Энэхүү асуултад хариулахад Бурханы шашныг сурталчлах Нийгэмлэгийн зорилт орших бөгөөд түүнийг

санаачлан үүсгэгч ч гэсэн үүнийг хүсч байгаа юм.

Өөрөөр хэлбэл, Бурханы шашныг сурталчлах Нийгэмлэг бурханы шашныг сурталчлахтай холбоотой бүх ажлыг хийдэг юм. Урт удаан түүхэндээ бурханы шашны соёлоороо бахархсаар ирсэн боловч өөрийн туурвин бүтээсэн шашны ариун номгүй Японы ард түмний хувьд "Бурхан багшийн сургаал" нь тэрхүү шашны ном болохыг тус Нийгэмлэг хүсэн ерөөж байгаа юм.

Тиймээс энэ номыг бүтээхдээ, түүнийг уншсан хүн бүр оюуны хэрэгцээ шаардлагаа хангадаг байхыг бодолцсон юм. Мөн хэнбугай ч гэсэн Бурхан багшийн агуу их дүртэй танилцах бололцоотой байх ёстой хэмээн үзэж энэ ном хүн болгоны ширээний ном, аяны үнэнч хань байхыг бодолцсон юм.

Нийгэмлэг нь эл ном болж л өгвөл айл болгонд байхыг, түүнтэй аль болохоор олон хүн танилцахыг хүсэн ерөөж байна. Нийгэмлэг, газар дэлхий дээр хүн бүр Бурхан багшийн сургаалтай танилцах тэр сайхан өдөр түргэн ирээсэй хэмээн хүсэн хүлээж байгаа юм.